



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/197

Цагаан-Уул сум

Г Газар эзэмшүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит XIV хуралдааны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр явагдсан газар эзэмших эрхийн гэрчилгээг дуудлага худалдаагаар өндөр үнэ өгч ялсан иргэнд газрыг хавсралтаар эзэмшүүлсүгэй.

2. Захирамжаар газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг сумын Газрын даамал (А.Энхбаатар), Улсын бүртгэгч (Д.Ичинхорлоо) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Сумын Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор сумын Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг Газрын даамал (А.Энхбаатар)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ч.Эрдэнэчулуун) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГОНЧИГНЯМ



/Zahiramj 2024/

Сумын Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 04-ний өдрийн
А/197 дугаар захирамжийн хавсралт

№	Ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр	Регистр	Нэгж талбары н дугаар	Газар эзэмшүүлэх			
				Байршил	Хэмжээ, м ²	зориулалт	Хугацаа
1	Гөрөөчин овгийн Нямдорж Мөнх-Ундрал	УП05241728	3885939	6-р баг Дэнж Магнай трейд ШТС-ын зүүн талд	1206	Шатахуун түгээх газар агуулах	60 жил
Дүн					1206		

_____ ооо _____